Сэндэн-4 тангийн эрт цагийн болон эдүгээ цагийн хэрэглээний тойм

Жинган[1,2], Хөгжилт[2], Э.Сансархуяг[3], Т.Ариунжаргал[3], Ш.Болд[1]

[1]АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
[2]Өвөр Монголын Үндэсний Их Сургууль, Хараат эмнэлгийн хороо
[3]Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль
Цахим шуудан: bold@mnums.edu.mn, Утас: 99111418

Түлхүүр үг:
Уламжлалт анагаах ухаан
Шар ус
Сэндэн-4
Эртний сурвалж бичиг
Судар

Товч утга:
Удиртгал: Уламжлалт анагаах ухаанд яс, үений үрэвсэлт өвчнийг (Osteoartrithis) шар усны өвчний ангилалд хамааруулж, үндсэн зургаан өвчний нэг болгодог. Онол ёсоор бол шар ус эрүүл хэвийн байдлаас тэнцвэрээ алдан арвидах, хорогдох, хямралдах хувиралтаар бие махбодыг хорлодог. Одоогоор олдож байгаа нэн эртний баримтаас үзэхэд Монголын уламжлалт анагаах ухааны төвөд, манж, монгол хэлээр бичсэн эртний сурвалж бичгүүдэд шар ус, түүний үүсэлт, үүрэг, хувиралт, өвчин болох ёс, эмчлэх аргын талаарх мэдээ, баримтууд ялангуяа Сэндэн-4 тангийн тухай цөөнгүй тэмдэглэгдэн үлджээ. **Зорилго:** Сэндэн-4 тангийн эрт цагийн болон эдүгээ цагийн хэрэглээг судар ном, сурвалжуудаас тодруулах. **Арга, аргачлал:** Уламжлалт анагаах ухааны судрууд нь уг гарал, бүтцийн хувьд олон шинжлэх ухааныг хамардаг учраас шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэдэг системийн нийтлэг аргуудыг ашиглах нь нэн зохимжтой байдаг[2]. **Үр дүн:** Сэндэн-4 тангийн эртний сурвалж ном болох товчоор “Анагаах ухааны дөрвөн үндэс” дэлгэрэнгүй нэр нь “Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндсээс увдисын үндэс хэмээх оршивай” номын 59 дүгээр бүлгийн шар усны өвчнийг засах бүлэгт: засахуйн арга нь ер хийгээд ялгалтай хоёр буй. Ерийн засахуй аргад идээ, ундаа, явдал дөрөв, эм, заслыг цагаан, хар шар усны өвчинд өөр өөрт нь шүтүүлтүгэй. **Дүгнэлт:** 1. Лувсандоржийн “Рашааны шим” сударт сэндэн 80, арүр 45 хийгээд цагаан жилз 40, шар мод 40 хувь хийж найруулсан тангаар шар усны халууныг эмчилнэ хэмээн бичээд энэ нь Сэндэн-4 тан хэмээн алдаршив гэж онцлон тэмдэглэжээ. 2. Ц.Сүрэнжав эмч өөрийн бүтээлдээ Сэндэн-4 тангийн найрлагыг Жигмэдданзанжамцын “Үзэгсдийн баясгалан” сударт тулгуурлан арүр, жүрүр тус бүр 3.2 гр, барүр 9.4 гр, сэндэн 16 граммыг нарийн талхдаж сайтар нийлүүлж найруулна гэсэн стандарт гаргасан байна.

Удиртгал: Уламжлалт анагаах ухаандяс, үений үрэвсэлт өвчнийг (Osteoartrithis) шар усны өвчний ангилалд хамааруулж, үндсэн зургаан өвчний нэг болгодог. Онол ёсоор бол шар ус эрүүл хэвийн байдлаас тэнцвэрээ алдан арвидах, хорогдох, хямралдах хувиралтаар бие махбодыг хорлодог. Тухайлбал: өвдөгний үений шар усны өвчний үед шар ус өвдөгний үенд хурж хавдах, шархиран өвдөх, хөдөлгөөн хязгаарлагдан хөндүүрлэх шинж тэмдэг илэрдэг. Шар ус арвидаж бадган хийгээд цустай харилцан хямралдаж өвдөгний үенд хурснаас хий, цусны гүйдэлд нөлөөлөх эсвэл бэртэл гэмтэл, булгарснаас болж халууны гэмээс шалтгаалан шар ус үенд хурж цустай харилцан хямралдаж хий, цусны гүйдэлд саад болдог хэмээн шар усны өвчний эмгэг жамыг тайлбарлах боломжтой юм. Эмчлэх аргын хувьд уламжлалт анагаах ухаан дахь дөрвөн ерөндгийн эм, заслын аргыг олон зуун жилийн турш хэрэглэж ирсэн арвин туршлагатай хэдий ч уг өвчнийг засч буй эмийн болон заслын үйлдлийн механизм одоог хүртэл тодорхой бус, тайлагдаагүй хэвээр байсаар байна. Монголын уламжлалт анагаах ухаан нь 5000 жилийн түүхэн хөгжлийн явцад өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, түүнээс сэргийлэх олон арван аргуудыг үүдэн бүтээсэн бөгөөд өнөөдөр ч эдгээр аргын заримыг нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд хэрэглэсээр байна[1]. Одоогоор олдож байгаа нэн эртний баримтаас үзэхэд Монголын уламжлалт анагаах ухааны төвөд, манж, монгол хэлээр бичсэн эртний сурвалж бичгүүдэд

шар ус, түүний үүсэлт, үүрэг, хувиралт, өвчин болох ёс, эмчлэх аргын талаарх мэдээ, баримтууд ялангуяа Сэндэн-4 тангийн тухай цөөнгүй тэмдэглэгдэн үлджээ.

Зорилго: Сэндэн-4 тангийн эрт цагийн болон эдүгээ цагийн хэрэглээг судар ном, сурвалжуудаас тодруулах

Арга, аргачлал:

1. Системийн түгээмэл, нийтлэг арга: Уламжлалт анагаах ухааны судрууд нь уг гарал, бүтцийн хувьд олон шинжлэх ухааныг хамардаг учраас шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэдэг системийн нийтлэг аргуудыг ашиглах нь нэн зохимжтой байдаг[2]. Энэ арга нь шинжлэх ухааны ойлголтуудыг стандартчилах, цэгцлэх, ялангуяа анагаахын шинжлэх ухааны эмнэлзүй, оношилгоо, өвчний ангилал, эм судлалын талаарх мэдлэг, төсөөллийг системчлэх, нэг мөр болгоход чухал үүрэгтэй тул бид системийн түгээмэл, нийтлэг аргыг Монголын анагаах ухаан дахь Сэндэн-4 тантай холбоотой мэдээ, баримтуудыг тогтоох, нэгтгэн дүгнэх, судлан гаргахад ашиглав.

2. Сурвалж бичгийн судлалын арга: Уг судалгааны арга нь сурвалж бичгийн эх, нэр, зохиогч, газар орон, онцлог, агуулга, тайлбар, харьцуулалт, хөрвүүлэг, нэрийн хэлхээ зэргийг нэгэн дор хамтатган судлахад оршдог[3]. Судалгаанд ашигласан гол хэрэглэгдэхүүн Сүмбэ хамба Ишбалжир, Миндол номун хан Жамбалчойжиданзанпэрэнлэй, Зоригт ван Жигмэдданзанжамц, гэлэн Чойжамц нарын бичсэн судар, номуудаас ажлынхаа зорилго, зорилтуудаа нийцүүлэн зохиогчийнх нь төрсөн болон амьдарч байсан цаг хугацаагаар хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлэн судалгааг явуулж Сэндэн-4 тангийн хэрэглээ, шинэлэг санааг бусад бүтээлтэй харьцуулан, шүүн тунгааж үзэв.

3. Магадлан жагсаах арга: Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргаар уламжлалт анагаах ухаан дахь шар усны өвчинд өргөн хэрэглэдэг Сэндэн-4 тангийн бүрэлдэхүүн хэсгийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгийг судлав. Магадлан жагсаах арга нь мэдээллийг төрөлжүүлж ангилахад хялбар, өгөгдөл цуглуулахад хялбар, эхний шатны үнэлгээ өгөхөд тохиромжтой, төлөвлөсөн ажлаа урьдчилан харах, цахим санд оруулахад зохимжтой, хялбар байдгаараа давуу талтай арга юм[4].

Үр дүн, хэлцэмж: Сэндэн-4 тангийн эртний сурвалж ном болох товчоор “Анагаах ухааны дөрвөн үндэс” дэлгэрэнгүй нэр нь “Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндсээс увдисын үндэс хэмээх оршивай” номын 59 дүгээр бүлгийн шар усны өвчнийг засах бүлэгт: засахуйн арга нь ер хийгээд ялгалтай хоёр буй. Ерийн засахуй аргад идээ, ундаа, явдал дөрөв, эм, заслыг цагаан, хар шар усны өвчинд өөр өөрт нь шүтүүлтүгэй. Цагаан шар усанд эмэнд нь: таван үндэс, сэндэн, гурван үрийг тос бурамтай холь. Хар шар усыг сэрүүн идээ, явдлаар зас. Эм нь: шар мод, нохойн хошуу, сэндэн, барүрийн талх, гүглийг нийлүүлж өг. Үесийн шар усанд гал хатгуур үйлд. Мах, арьс, судал, яс бүгдэд усан дэвтээлэг сайн. Түүний хойно сэндэнгийн тосон эмээр өвчнийг тасална[5].

Сүмбэ хамба Ишбалжирын “Дөрвөн рашаан”-ны “Рашааны цагаан шүүдэр” номын “Хэсэг бусаг өвчин”-ий бүлэгт: “Шар усны өвчний шалтгаан нь идээ ундааны тунгалаг нь цус болох, цусны цөв цөс болох, цөсний тунгалаг нь шар ус болдог. Гэвч архи дарс, мах зэрэг идээ ундааг хэтэрхий идэж ууснаар эс зохилдвол шар ус арвидаж голдуу арьс үенүүдэд оршсоноос болно. Шар усанд хар, цагаан хоёр зүйл буй. Шар усны өвчний орших орон нь арьс, үес болох бөгөөд эдгээр нь амархан өвчин үүсэх орон болдог” хэмээн бичсэн байна[6].

Миндол номун хан Жамбалчойжиданзанпэрэнлэйн “Увдисын далай” (man ngag rin chen ‘byung gnas) сударт: “Шар усны зөөлнөөр засах ганцаар чадагч сэндэн ургах газар нь өмнө Мон орон, Балба орон болой. Иш нь маш их, навч мөчир зэргийн олонх нь рагда зандантай адил. Модны өнгө өчүүхэн улаан, хорт өргөст мэт түүнд цагаан, хар хоёр зүйл байна. Модны тодотгогч нь цагаан, улаан зандан, чихэр өвс, сэндэн дөрөв” хэмээжээ[7].

Ламын гэгээн Лувсанданзанжанцан. “Хамба номын ханы буман зарлигаас увдист рашааны дусал хэмээх оршивай” сударт сэндэнгийн хэрэглээг дараах байдлаар тэмдэглэжээ.

- Арга мухардсанд судлын туулга үлэмж сайн
- Халуун шар усны өвчинд
- Сэндэн, мана, лидрийн ширгээсэн танд
- Шар усыг гурван эм, барагшин, арүр, гүргэмийн найралт
- Хүйтэн шар усан өвчний олонхид
- Хүчин ихт гарьд тавыг таацуулан өг.
- Халуун шар усны өвчинд
- Сэндэн, мана, лидэрийн ширгээсэн танд
- Шар усыг гурван эм, барагшин, арүр, гүргэмийн найралт
- Хүйтэн шар усан өвчний олонхид
- Хүчин ихт гарьд тавыг таацуулан өг гэж тодорхой тэмдэглэжээ[8].

Жигмэдданзанжамцын “Үзэгсдийн баясгалан”-д: “Барүр, арүр, жүрүр, сэндэн зэрэг дөрвөн хөл эмээр бүрэлдэж усан хаванг хатаана” гэжээ. Энэ бүтээлд тулгуурлан “БНХАУ-ын Эм найрлагын баримжаа” (нөхвөр дэвтэр)-д: “Шар сэндэн 500 гр, барүр 300 гр, арүр, жүрүр тус бүр 100 гр” найруулна. Халууныг арилгах, шар усыг хатаах чадалтай. Халуун чанартай үе гишүүний шар ус, усан хаванг арилгана хэмээн тэмдэглэжээ.[25] Энэхүү бүтээлд арүр 1 цэн, барүр 3 цэн, жүрүр 1 цэн, сэндэн 5 цэнгээр найруулсан тан нь усан хаванг хатаана.

Усан хаван бол эс шингэсэн хийгээд халуун өвчнийг сэрүүнээр засах нь хэтэрсэн, адын нөхцлөөр ханиах нь олширсон, туулгын дараа идээ, явдал мөр зэрэг нь буруудснаас хянгар шилбээс дээш хавагнах бөгөөд хаван нь бүх биед түгэж, баас шээс нь үргэлжлэн шар устай хамт биед нь дүүрээд үхэхэд хүрмой. Үүнийг засахад анхдугаар гурван хоногт, бага үдийн хэрд Ави-6-гийн тан, Сэндэн-4 танг тус тус өгнө. Чухамдаа царайны өнгө нь гоо үзэсгэлэнгүй болж, нүдэнд нь ус эргэж, удах тусмаа бүх биед нь түгмой. Үүнд анх эхлээд Сэндэн-4 тан, Их тан-10, Их

тан-25 зэргийг өг. Мөнгөн ус-18, 14, Илжигний цус-25, Тогооны хөө-8 зэргийг уулгаж, гаднаас нь түрхлэгийн хар эмийг түрхэнэ. Доод бие хавдах өвчин бол бөгс хавдаж, хавдар нь чийрэг хатуу, халуун хямарч маш их халуурна. Энэ нь хий оршсон өвчин мөн. Үүнд: Гүглийн ганц тан, Сэндэн-4 танг олонтаа уулгана[9].

Лувсанчойнпил. "Нандин эрдэнийн шимийн хураангуй". Төвөд хэлний модон барын сударт: "Сэндэн бол муу цус, шар усыг хатаана", "Сэндэн, арүр, жилз, шар модоор найруулсан тан бол халуун шар усыг хатаана" гэжээ[10].

Сумади Важра буюу Лувсандоржийн "Эмийн найрлагын хэмжээний аймаг нугуудыг товч төдий нэгэн зүгт байгуулсан бүхнээ туст рашааны шим хэмээх оршивай" төвөд хэлний модон барын сударт Сэндэн-4 хэрэглээг сонирхолтой өгүүлсэн байна. Уг судрын төгсгөлийн үгэнд Сумади Важра нэрт бээр оюун дорой нэгэнд элдэв эмийн найрлага эрхгүй хэрэг болох үед олон судрыг унших зав чөлөөгүй тулсан цагт их тустайг санаж, гараар бичвэй. Үүнийг үзсэн амьтанд агуу их тус болох болтугай. Дэчинлхүндүвлэн их хийдийн барт бүтээвэй гэсэн байна. Энэ сударт: Сэндэн 80, арүр 45 хийгээд цагаан жилз 40, шар мод 40 хувь хийж найруулсан тангаар шар усны халууныг хатаана. Энэ нь Сэндэн-4 тан хэмээн алдаршив. Тэмбүү ярыг засах үеийн эм нь эхлээд Сэндэн-4 танг өг. Түүнээс судал, шээсээр халуун, хүйтэн аль болсныг шинжил гэж заасан байна[11].

Гэлэн Чойжамц. "Маш гайхамшигт баярын хурмын сан" сударт: "Ялангуяа хүзүү хөших, чичрэх, хатгах зэрэгт Сэндэн-2-ын тан өгвөл магад тустай болой. Дараа нь галт бумбаар тойруул хэмээжээ. Энэ мэтээр дээрх эрдэмтэд өөр өөрсдийн бүтээлдээ сэндэн, сэндэн орсон жор, Сэндэн-4 тангийн талаар олонтоо өгүүлэхдээ хувь эмчийн туршлага, бусдын эмчилгээний арга, Энэтхэг, Төвөдийн эртний эмч нарын бүтээлд тулгуурлан маш өргөн ухагдахуунаар, олон талаас нь өгүүлжээ[12].

Хорьдугаар зууны дунд үеэс 21 дүгээр зууны эхэн гэхэд дараах эрдэмтэд Сэндэн-4 тангийн хэрэглээ, үйлчилгээг орчин цагийн анагаах ухааны судалгааны аргад суурилан шинэ мэдлэг, мэдээллийг бий болгосон байна.

Ц.Сүрэнжавын "Монгол анагаах ухааны эмчилгээний судлал" номонд: "Сэндэн-4 жор Жигмэдданзанжамцын "Үзэгсдийн баясгалан" номоос ирсэн бөгөөд найрлага нь арүр, жүрүр тус бүр 3.2 гр, барүр 9.4 гр, сэндэн 16 граммыг нарийн талхдаж сайтар нийлүүлж найруулна. Голдуу засах нь шар усны халууныг арилгаж, усан хаванг хатаахад хэрэглэнэ. Хэрэглэх арга нь удаа бүр 1.5-3 гр-ийг усанд чанаж бүлээнээр нь ууна[13].

Түүнчлэн Сэндэн-4 тан эмийн хими, фармакологи, хор судлалын талаарх судалгаа нэлээдгүй хийгдсэн байна. Жишээлбэл: Tian Zi зэрэг судлаачид Сэндэн-4 тан эмийн химийн бүрэлдэхүүнийг баганат хроматографи, нимгэн үет хроматографи, спектрофотометрийн аргуудаар судалж 8 төрлийн дан нэгдэл (3-гидрокси, 5-метил, 8-метаокси, 1, 4 бензохинон; 2,6 диметаокси 1, 4 бензохинон, myrocetin г.м) ялган авч химийн бүтэц байгууламжийг тодорхойлсон байна[13]. Dong Yu зэрэг эрдэмтэд Сэндэн-4 тан эмэнд агуулагдах зарим биологийн идэвхт бодисын (жүрүрийн гликозид, рутин, myrocetin г.м) тоо хэмжээг HPLC-ийн аргаар тодорхойлсон байна[15]. Xu Liang зэрэг эрдэмтэд сэндэн-4 тан эмийг ус болон янз бүрийн ус-этанолын (35%, 55%, 75%, 95%) уусмалаар хандлан тэдгээрийн үрэвслийн эсрэг, өвдөлт намдаах үйлдлийг туршилтын жижиг хулгана дээр судалж судалгааны үр дүнд 95%-ийн этанолын хандын үрэвсэл дарах, өвдөлт намдаах үйлдэл хамгийн их буюу 60% байгааг тогтоожээ[16].

Fan Lei зэрэг эрдэмтэд Сэндэн-4 танг капсул эмийн хэлбэрт оруулж үрэвслийн эсрэг, өвдөлт намдаах үйлдэл болон архаг болон хурц хорон чанарын судалгааг туршилтын жижиг хулгана дээр хийж Сэндэн-4 капсул эмийг өдөрт 60, 30 ба 10 г/кг тунгаар 3 сар, 120г/кг тунгаар (хүний өгөх эмчилгээний тунгаас 863 дахин их) уулгаж архаг болон хурц хорон чанарыг судлахад ямар нэгэн хордлогын нөлөө үзүүлээгүй байна[17,18]. Li Shi Rong, Bai Pu зэрэг судлаачид туршилтын том хулганы өвдөгний үенд шар усны өвчний эмгэг загвар үүсгэж Сэндэн-4 тан эмийн үрэвслийн эсрэг үйлдлийг судалж цусан сийвэн дэх TNF-α, PGE-2, IL-6 зэрэг үрэвслийн цитокинуудыг ELISA–ийн аргаар тодорхойлжээ[19,20]. Tai Ping, Liu Zhi Gang зэрэг судлаачид Сэндэн-4 тан эмийг эмчилгээнд Бойгар-10, Жонлон-5, Нару-3, Мөнгөн ус-18, Эрдэнийн үрэл, Сарангарьд зэрэг эмүүд болон хатгах засалтай хавсруулан үе гишүүний шар усны өвчнийг анагаах эмнэл зүйн судалгааг тус тус хийсэн байна[21,22].

Урнаа нарын судалгааны ажлын үр дүнд Сэндэн-4 тангийн нийлмэл эмээс ашигтай бодисыг нь ялган авч, бичил биет (microorganism)-ийг дарангуйлах туршилт хийн, бага температурт хатаах аргыг ашиглан Сэндэн-4 тангийн идэвхтэй бүрэлдэхүүнийг өндөр түвшинд ялган, улмаар нано эмульс (Nano-emulsion) гарган авч олон улсын стандартад нийцсэн олон талт туршилтаар баталгаажуулжээ. Судалгааны явцад Сэндэн-4 тангаар гадар хэрэглэх орчин үеийн хэлбэртэй эмийн бэлдмэл хийж арьсны өвчний салбарт нэвтрүүлэх боломжтой болохыг тогтоов. Шинээр гарган авсан нано эмульсийн арьсны харшлын тестийг таниулах зөвшөөрөл авсан 120 сайн дурынхан дээр туршихад 6.6%-д нь хөнгөн хэлбэрийн улайлт илэрсэн ч эмчилгээний дараа бүрэн эдгэрсэн. Эмнэл зүйн ажиглалтын хувьд хяналтын бүлгийн 125 хүнийг 3 хуваан эмчилгээнд хамруулснаас эмчилгээний үр дүн тус бүр 81.5%, 67.4% болон 62.3%-тай байлаа. Түүнчлэн арьсны загатнаат өвчний 112 тохиолдлыг 2-12 долоо хоногийн турш нано эмульсээр эмчилсний дараа бүх шинж тэмдэг бүрэн арилсан нь энэхүү эмульс эмчилгээний өндөр идэвхтэй байгаа нь тогтоогдсон байна[23].

Судалгаанд авсан сурвалж бичгүүдэд Сэндэн-4 тангийн эрт цагийн хэрэглээг тодорхой бичиж үлдээжээ. Ялангуяа Жигмэдданзанжамцын "Үзэгсдийн баясгалан"-д: Сэндэн-4 танг барүр, арүр, жүрүр, сэндэн зэрэг дөрвөн хөл эмээр найруулж усан хаванг хатаана гэж тэмдэглэсэн. Энэ бүтээлд тулгуурлан Сэндэн-4 танг шар сэндэн 500 гр, барүр 300 гр, арүр, жүрүр тус бүр 100 граммаар найруулах

болсон байна. Өнөөгийн байдлаар Сэндэн-4 танг шар усны халууныг арилгаж, усан хаванг хатаахад голлон хэрэглэж байна.

Дүгнэлт:

1. Лувсандоржийн “Рашааны шим” сударт сэндэн 80, арүр 45 хийгээд цагаан жилз 40, шар мод 40 хувь хийж найруулсан тангаар шар усны халууныг эмчилнэ хэмээн бичээд энэ нь Сэндэн-4 тан хэмээн алдаршив гэж онцлон тэмдэглэжээ.
2. Ц.Сүрэнжав эмч өөрийн бүтээлдээ Сэндэн-4 тангийн найрлагыг Жигмэдданзанжамцын “Үзэгсдийн баясгалан” сударт тулгуурлан арүр, жүрүр тус бүр 3.2 гр, барүр 9.4 гр, сэндэн 16 граммыг нарийн талхдаж сайтар нийлүүлж найруулна гэсэн стандарт гаргасан байна.

Ном зүй:

1. *Ш.Болд. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, х.16*
2. *Churchman, C.W. 1968. The Systems Approach. New York, NY, USA: Dell Publishing.*
3. *Болд Ш. Монгол уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006*
4. *Atul Gawande. The Checklist Manifesto. 2009, 208 p*
5. *Анагаах ухааны дөрвөн үндэс (bdud rtsi snying po yan lag brgyad pa gsang ba man ngag gi rgyud ces bya ba). Хөрвүүлсэн: Ш.Чоймаа, Б.Энхсувд, Т.Мөнхням. Редактор: Ш.Болд, УБ, 2020,*
6. *Сүмбэ хамба Ишбалжир. “Дөрвөн рашаан”. Хөх хот, Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо, 1998*
7. *Миндол номун хан Жамбалчойжиданзанпэрэнлэй. “Увдисын далай” (man ngag rin chen ‘byung gnas). Төвөд хэлнээс орчуулсан: Ш.Болд, Х.Улаан-Од, Д.Шагдарсүрэн, УБ, 2023,*
8. *Ламын гэгээн Лувсанданзанжанцан. “Хамба номын ханы буман зарлигаас увдист рашааны дусал хэмээх оршивай”. Төвөд хэлний модон барын судар. (Ш.Болдын хувийн номын санд хадгалагдаж байна)*
9. *Зоригт ван Жигмэдданзанжамц. “Үзэгсдийн баясгалан”. (Төвөд эх, хуучин орчуулгыг харьцуулан шинэчлэн орчуулсан Ш.Болд). Хэвлэгдээгүй гар бичмэл.*
10. *Лувсанчойнпил. “Нандин эрдэнийн шимийн хураангуй”. Төвөд хэлний модон барын судар. (Ш.Болдын хувийн номын санд хадгалагдаж байна)*
11. *Сумади Важра буюу Лувсандорж. “Эмийн найрлагын хэмжээний аймаг нугуудыг товч төдий нэгэн зүгт байгуулсан, бүхнээ туст рашааны шим хэмээх оршивай”. Төвөд хэлний модон барын судар. (Ш.Болдын хувийн номын санд хадгалагдаж байна)*
12. *Гэлэн Чойжамц. “Маш гайхамшигт баярын хурмын сан”. Төвөд хэлний модон барын судар. Их хүрээ, 1922, (Ш.Болдын хувийн архив).*
13. *Ц.Сүрэнжав. Монгол анагаах ухааны эмчилгээний судлал, Хөххот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1999.*
14. 日滋，武娜，董玉，等. 蒙药森登-4学成分的研究内蒙古大学学报（自然科学版）2014，45（3）：295-298.
15. 董玉，武娜，贾鑫，等. HPLC 法同时测定蒙药复方森登-4中栀子苷、芦丁及杨梅素的含量[J]，北京中医药大学学报，2012，35（12）:839-842.
16. 乞良，蒙药森登-4汤药效物质基础研究[D].沈阳药科大学博士学位论文，2006，12:1
17. 范蕾，常福厚，韩瑞兰，等. 森登-4胶囊安全性研究[J].毒理学杂志，2010，24（3）:246-248.
18. 范蕾，常福厚，韩瑞兰. 森登- 4胶囊的药理学作用研究[J].内蒙古医学院学报，2010，32（6）:558-560.
19. 李时荣，张文涛，田滋，等. 蒙药森登-4 对胶原性大鼠关节炎的实验研究[J]. 内蒙古医科大学学报，2013，35（6）:479-483.
20. 乌埔，信莎莎，董玉. 蒙药复方森登- 4 抗佐剂型关节炎作用的研究[J].北京中医药大学学报，2015，38（3）:186-189.
21. 长平，白玉华，珠娜.蒙药结合针灸治疗类风湿性关节炎98例临床分析[J].中国民族医药杂志，2014,10:14-15.
22. 刘志刚，牡丹. 蒙医治疗关节黄水病体会[J].中国民族医药杂志，2015，4:22.
23. *Wurina. Сэндэн-4 тангаас нано хэмжээстэй шинэ бэлдмэл гарган авч, арьсны зарим өвчнийг үр дүнтэй эмчлэх нь. Анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан нэг сэдэвт бүтээлийн* хураангуй. УБ, 2019

An overview of the early and modern usage of Senden-4 tang

Jingang[1,2], Hugejiletu[2], Sansarkhuyag E[3], Ariunjargal T[3], Bold Sh[1]

[1]International School of Mongolian Medicine, MNUMS, Mongolia
[2]Affiliated Hospital of Inner Mongolia University for the Nationalities, Tongliao, Inner Mongolia Autonomous Region, People's Republic of China
[3]Mongolian University of Pharmaceutical Sciences
E-mail: bold@mnums.edu.mn, Tel: +976-99111418

Background: Traditional Mongolian medicine has developed dozens of methods for diagnosis, treatment, and prevention of diseases in the course of 5000 years of historical development. Today, some of these methods are still used to protect the health of our population. In the ancient medical texts of traditional Mongolian medicine, written in Tibetan, Manchu, and Mongolian languages, information, and facts about *shar us* (yellow water), its origin, role, mechanism of transformation into disease, and treatment methods were recorded. In particular, there have been many mentions of Seng ldeng-4 decoction for the treatment of *shar us*.
Aim: To clarify the past and present use of Seng ldeng-4 decoction from ancient medical books and sources.
Materials and Methods: We used the following study methods: multipurpose system method, manuscripts, primary source methods, and checklist method.
Results: The ancient medical books clearly recorded the early use of Seng ldeng-4 decoction. Especially in Mongolian ancient researcher, Jigmeddanzanjamts wrote in his book "mthong ba dga' byed": Seng ldeng-4 decoction will be composed with four raw materials such as barura, arura, jurura, and seng lden. It is noted to cure swelling and edema. Seng ldeng-4 decoction is mainly used to remove the warmth of *shar us* (yellow water) and dry edema.
Conclusions:

1. Luvsandorji's "Ambrosia Essence" sutra will be composed by seng lden 080, arura 045, white jilze (*Gentiana crassicaulis Duthie ex Burk*) 040, and yellow wood (*Berberis sibirica)* 040. It is written that this decoction will cure the warm disease of *shar us*. Since then, it has become known as Seng ldeng-4 decoction.
2. Doctor Ts. Surenjav in his work, based on Jigmeddanzanjamts' "mthong ba dga' byed" medical sutra, made a standard for the composition of Seng ldeng-4 decoction, that 3.2 grams of arura and jurura, 9.4 grams of barura, and 16 grams of seng ldeng should be carefully mixed together. Currently,

Keywords: Traditional medicine, Yellow water, Seng ldeng-4, Decoction, Medical sutra